



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 120

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ гүйцэтгэлээр зардлын төлөвлөгөөгөө 45,534.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь ажиллагсдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд 41,340.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 77 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2023 оны орлого, зардлыг 425,391.0 мянган төгрөгөөр буюу цэвэр ашиг, алдагдалгүй ажиллахаар баталсан байна. Энэ тогтоолын хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

0702700407

Тайлант онд 4 зорилт, 48 арга хэмжээг хүрээнд үйл ажиллагаа явуулахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж тайлагнасан ба аймгийн Засаг дарга 90.8 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,969.0	23,754.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,179,070.6	4,101,263.9
Нийт хөрөнгийн дүн	4,194,039.6	4,125,018.1
Нийт өр төлбөрийн дүн	51,461.8	13,194.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,142,577.8	4,111,823.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,194,039.6	4,125,018.1
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн	71,628.3	81,519.9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,053.3	3,623.4
Нийт ашиг алдагдал	63,574.9	77,896.5
Түсээсийн орлого	6,846.3	7,609.3
Бусад орлого	323,220.0	377,279.4
Борлуулалт маркетингийн зардал	266,928.8	362,858.5
Ерөнхий ба удирдлагын зардал	208,373.7	124,215.4
Бусад зардал	11,873.0	6,465.5
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-93,534.3	-30,754.2
Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал	-93,534.3	-30,754.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмчид гарсан өөрчлөлт	4,236,112.2	4,142,577.8
Тайлант оны үр дүн	-93,534.3	-30,754.2
Эцсийн үлдэгдэл	4,142,577.8	4,111,823.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Мөнгөн орлогын дүн	380,274.6	466,408.7
Мөнгөн зарлагын дүн	379,842.1	466,050.7
Үндсэн үйл ажиллагааны ЦМГ	432.5	357.9
Бүх ЦМГ	432.5	357.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	404.7	837.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	837.3	1,195.2

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа:

Мөнгөн гүйлгээний тайланд ашиглалтын зардал болох 1.3 сая төгрөгийг ажиллагсдад төлсөн зардалд, бараа материалын тайлан өмнөх онд аудит хийсэн тайлангийн үлдэгдлээс 0.044 сая төгрөгөөр дутуу, тайлант оны эцсийн үлдэгдэл тодруулга тайлангаас 1.3 сая төгрөгөөр дутуу, тайлант оны үр дүнг 1.2 сая төгрөгөөр дутуу, авлагыг 0.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн 8 зөрчил² илэрч, 0.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 5 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Цалингийн тооцоогоор 0.3 сая төгрөг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т "гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Илүү тооцож олгосон цалинг төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Амралтын цалин тулгахад 0.2 сая төгрөг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.5-т "Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралт олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын баталсан Ээлжийн амралт олгох, ээлийн амралтын цалин тооцох журмын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт: Давхардуулан олгосон цалинг төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.Холбогдох анхан шатны баримтгүй 0.5 сая төгрөгийг шатахууны зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтгүй зарцуулсан мөнгөн хөрөнгийг төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Албаны бус хэрэглээнд 0.9 сая төгрөгийн шатахууныг нярваар дамжуулалгүйгээр зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" ;" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд үнэн зөв, энгийн ойлгомжтой хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

Бараа мматериалын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд 1.8 сая төгрөгийн барааг шаардах хуудасгүйгээр зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

Шийдвэрлэлт: Бараа материалыг шаардах хуудсаар зарцуулж анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Ажиллагсдад олгосон 0.2 сая төгрөгийн цалинг татварын байгууллагад дутуу тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" 25.7-т "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан,

холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Татварын байгууллагад дутуу тайлагнасан цалинг нөхөн тайлагнаж залруулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант хугацаанд 1.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, харилцагчидтай тооцоо нийлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Харилцагчтай тооцоо нийлж өглөгийг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Хөрөнгийн тооллогын илтгэх хуудасгүй, өмч хамгаалах зөвлөл тооллогын үр дүнг хэлэлцээгүй, тооллогын үр дүнд нягтлан бодогч тооцоо бодоогүй агуулахын бүртгэл хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд чанартай үр дүнтэй зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. УТҮГ-ын батлагдсан төлөвлөгөөнд түрээсийн орлого тусгасан байхад харилцагчидтай гэрээ байгуулахдаа ашиглалтын зардал авах гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 77 дугаартай "Улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны төлөвлөгөөг батлах тухай" тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Түрээслэгч нартай түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж төлбөрийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

УТУГ-ын эзэмшилд байгаа 5539 метр квадрат биеийн тамир спортын зориулалт бүхий газрыг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"; Аймгийн ИТХ-ын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 11 дугаартай " Газрын төлбөрийн бүс, хил зааг, хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: УТУГ-ын эзэмшилд байгаа газрыг данс бүртгэлд тусгах


Илрүүлэлт 2:

Орлогыг нэр төрлөөр бүртгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС1 "Үнэн зөв ба толилуулга, нийцсэн байдал" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг нэр төрлөөр бүртгэл хөтөлж холбогдох журнал нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
						Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	4	4.1	-	-	4	4.1	4	4.1	-	-	-
Дүн	4	4.1	-	-	4	4.1	4	4.1	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	10	5.5	3	1.0	4	4.5	3						
Дүн	10	5.5	3	1.0	4	4.5	3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн УТҮГ	2	120.8	-	-	2	120.8		
Нийт дүн	2	120.8	-	-	2	120.8		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-